



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/34 ВЧА 2018/29 КСТА-ОИТС Мандалговь хот

Г

Г

Зөрчлийг арилгуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Цагаандэлгэр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа аудит хийх явцад 4,700,000.00 /дөрвөн сая долоон зуун мянган/ төгрөгийн дараах зөрчлүүд илрэлээ. Үүнд:

1. Сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь 2,000,000.00 /хоёр сая/ төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д /дансын өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гулгээг гарахаас нь өмнө хянаан, баталгаажуулах;/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, ур дунг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчийн тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ заасныг;

2. Сангийн хөрөнгөөс 1,700,000.00 /нэг сая долоон зуун мянган/ төгрөгийг сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Цагдаагийн согтууруулах ундаа хэрэглэсэн үед хэмжих багаж хэрэгсэл” зардалд, 1,000,000.00 /нэг сая/ төгрөгийг батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй, иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй “Цэцэрлэгийн зураг төсөв” зардалд тус тус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/, 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно/, 60.3.1.-д /орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/, 60.3.6-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн

аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын язцад илрэсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсон;/, 4.1.4-т /Байгууллага иргэдтэй үүссэн материаллаг буюу наасжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлжээ актаар баталгаажуулаагүй;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Харилцагч байгууллагатай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах ажлыг зохион байгуулах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангагч, зориулалтын бус зардалд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг жагсаалтаас хасч тодотгох,

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, зөрчлийг арилгасан талаар 2018 оны 03 дугаар сарын 01-ний дотор, зориулалт бус зарцуулалттай холбоотой зөрчлийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор арилгаж, албан шаардлагын биелэлтийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Цагаандэлгэр сумын Засаг дарга Д.Буджав, нягтлан бодогч Т.Хүдэрччулуун нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ	
ОГСОН: АХЛАХ АУДИТОР: 	ЗӨВШӨӨРСӨН: ЗАСАГ ДАРГА:
Д. ИХБАЯР НЯГТЛАН БОДОГЧ: 	Д. БУДЖАВ Т.ХҮДЭРЧЧУЛУУН
4817144213 ЗИОА0039 9033475	

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургуулна.